

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрд сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/42/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Арвайхээр

2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Ахлах аудитор: С.Шийлэгмаа

Утас: 70323833 Цахим хаяг: Shiilegmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндангийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

1022-02-24 № 120
танай _____-ны № _____-т

Бүрд сумын Соёлын төвийн эрхлэгч
О.Эрдэнэтуяа танаа

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Санхүүгийн тайлангаар 1,370.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 7.7 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгааг тооллогын комисс тоолсон гэх боловч тоолсон тооллогын бүртгэл байхгүй тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, нягтлан бодогч өөрийн бүртгэлтэй тулган шалгаагүй.
2. Харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар өр, авлага, тооцоогүй байгааг баталгаажуулаагүй.
3. Оны эхэнд 7.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 7.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй болж бараа материалын хөдлөл өөрчлөлт гарсан боловч эд хариуцагч тайлан гаргаагүй.
4. Газар эзэмших эрх, номын фонд дансны хөрөнгийн ашиглах хугацааг 0 жилээр тооцож санхүүгийн программд тусгасан.
5. Бусад үндсэн хөрөнгийн дансанд 2.3 сая төгрөгийн газар, 20.4 сая төгрөгийн номыг хамт бүртгэсэн.
6. Номын фондын 20.4 сая төгрөгийн номыг бөөн дүнгээр бүртгэсэн тул тоо ширхэг, нэгж үнэ нь тодорхойгүй байгаагаас тооллогод хамрагдсан эсэх, хөрөнгө бодитоор оршин буй эсэх нь тодорхойгүй.

7. Шатахуун зарцуулалтын анхан шатны баримт бүрдүүлээгүй, замын хуудас үйлдэж тооцоо бодоогүйгээс 2.9 мянган төгрөгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 5.1.4, 12.2, 12.2.1, 13.7, 14 дүгээр зүйл, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйл, 67.1, 67.2, 68 дугаар зүйлийн 68.1, 72 дугаар зүйлийн 72.4.1, 72.4.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал заалтуудыг зөрчсөн. УСНББОУС-12, 17-тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн **Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал**, гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй бэйвэл материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А			
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
Байгууллагын нэр: Бүрд Соёлын төв		Тайлант хугацаа: 2021.12.31	
Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8.068.019.00	8.723.164.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	1.048.855.00	1.000.000.00
331	авлага	1.048.855.00	1.000.000.00
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	7.019.164.00	7.723.164.00
354	Хангамжийн материал	7.019.164.00	7.723.164.00
3542	Аж ахуйн материал	7.019.164.00	7.723.164.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1.325.901.052.18	1.375.409.876.35
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1.325.901.052.18	1.375.409.876.35
392	Биет хөрөнгө	1.301.749.652.18	1.351.258.476.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1.249.627.389.99	1.306.369.873.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-10.195.821.40	-15.402.602.17
39205	(компьютер)	25.930.085.00	25.930.085.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16.301.843.51	-17.389.847.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40.968.868.00	40.968.868.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17.678.909.90	-18.937.784.93
39213	зүйлс	6.940.279.00	6.940.279.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	22.459.605.00	22.779.605.00
393	Биет бус хөрөнгө	24.151.400.00	24.151.400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	24.151.400.00	24.151.400.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=II+I	1.333.969.071.18	1.384.133.040.35
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2.310.790.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2.310.790.00	
413	Өглөг	2.310.790.00	
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	399.515.92	
4136	Бусад өглөг	1.911.274.08	
41361	Байгууллагад төлөх өглөг	1.911.274.08	
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1.331.658.281.18	1.384.133.040.35
51	Засгийн газрын хувь оролцоо	1.331.658.281.18	1.384.133.040.35
511	/Засгийн газрын сан/ орон нутгийн	191.140.434.00	191.140.434.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	942.483.122.87	994.957.882.04
5121	Өмнөх үеийн үр дүн	942.483.122.87	942.483.122.87
5122	Тайлант үеийн үр дүн		52.474.759.17
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	198.034.724.31	198.034.724.31
VI	ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1.333.969.071.18	1.384.133.040.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А			
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
Байгууллагын нэр: Бүрд Соёлын төв		Тайлант хугацаа: 2021.12.31	
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		173.492.384.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		56.917.484.00
120	Нийтлэг татварын бус орлого		56.917.484.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		56.917.484.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		175.000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		56.742.484.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		116.574.900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		116.574.900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн		116.574.900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		121.017.624.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ		121.017.624.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		119.209.851.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		50.502.924.00
210101	Үндсэн цалин		47.176.700.00
210105	Гэрээт ажлын хөлс		3.326.224.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		8.377.854.80
210201	Тэтгэврийн даатгал		6.206.255.00
210202	Тэтгэмжийн даатгал		542.900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		434.300.00
210204	Ажилгүйдлийн даатгал		108.599.80
210205	Эрүүл мэндийн даатгал		1.085.800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		46.074.969.00
210301	Гэрэл, цахилгаан		353.469.00
210302	Түлш, халаалт		45.721.500.00
2104	Хангамж, бараа материалын зардал		5.257.699.92
210401	Бичиг хэрэг		554.899.12
210402	Тээвэр, шатахуун		2.815.000.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		797.000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1.090.800.00
2105	Нормативт зардал		35.200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		35.200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		286.400.00
210604	Урсгал засвар		286.400.00
2107	Томилолт, зочны зардал		292.000.00
210702	Дотоод албан томилолт		292.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		512.254.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил		512.254.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		7.870.549.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		316.890.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		7.553.659.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1.807.773.28
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1.807.773.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1.807.773.28
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		52.474.759.17
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		52.474.759.17

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Бүрд Соёлын төв

Тайлант хугацаа: 2021.12.31

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191.140.434.00	198.034.724.31	942.483.122.87	1.331.658.281.18
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			52.474.759.17	52.474.759.17
18				
19	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191.140.434.00	198.034.724.31	994.957.882.04	1.384.133.040.35

**Бүрд сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А			
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			
Байгууллагын нэр: Бүрд Соёлын төв		Тайлант хугацаа: 2021.12.31	
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		116.749.900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		175.000.00
120	Нийтлэг татварын бус орлого		175.000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		175.000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		175.000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		116.574.900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		116.574.900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн		116.574.900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		116.749.900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		116.749.900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		114.800.126.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		51.902.439.92
210101	Үндсэн цалин		48.802.439.92
210105	Гэрээт ажлын хөлс		3.100.000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		7.328.999.80
210201	Тэтгэврийн даатгал		5.157.400.00
210202	Тэтгэмжийн даатгал		542.900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		434.300.00
210204	Ажилгүйдлийн даатгал		108.599.80
210205	Эрүүл мэндийн даатгал		1.085.800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		46.074.969.00
210301	Гэрэл, цахилгаан		353.469.00
210302	Түлш, халаалт		45.721.500.00
2104	Хангамж, бараа материалын зардал		5.526.140.00
210401	Бичиг хэрэг		232.100.00
210402	Тээвэр, шатахуун		2.815.000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1.000.000.00
210404	Ном, хэвлэл		481.500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		997.540.00
2105	Нормативт зардал		316.400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		316.400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1.426.924.00
210604	Урсгал засвар		1.426.924.00
2107	Томилот, зочны зардал		292.000.00
210702	Дотоод албан томилот		292.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		1.641.254.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил		1.641.254.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		291.000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		291.000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1.949.773.28
2132	Бусад урсгал шилжүүлэг		142.000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		142.000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1.807.773.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1.807.773.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		

Бүрд сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГТ-1					
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН					
Байгууллагын нэр: Бүрд Соёлын төв				Тайлант хугацаа: 2021.12.31	
Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	117.425.400.00	116.749.900.00	675.500.00	99.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117.425.400.00	116.749.900.00	675.500.00	99.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	117.279.900.00	114.800.126.72	2.479.773.28	97.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54.287.900.00	51.902.439.92	2.385.460.08	95.61
210101	Үндсэн цалин	54.287.900.00	48.802.439.92	5.485.460.08	89.9
210105	Гэрээт ажлын хөлс		3.100.000.00	-3.100.000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	7.328.400.00	7.328.999.80	-599.8	100.01
210201	Тэтгэврийн даатгал	5.157.600.00	5.157.400.00	200	100
210202	Тэтгэмжийн даатгал	542.400.00	542.900.00	-500	100.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	434.400.00	434.300.00	100	99.98
210204	Ажилгүйдлийн даатгал	108.000.00	108.599.80	-599.8	100.56
210205	Эрүүл мэндийн даатгал	1.086.000.00	1.085.800.00	200	99.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	46.076.000.00	46.074.969.00	1.031.00	100
210301	Гэрэл, цахилгаан	674.200.00	353.469.00	320.731.00	52.43
210302	Түлш, халаалт	45.062.300.00	45.721.500.00	-659.200.00	101.46
210303	Цэвэр, бохир ус	339.500.00		339.500.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	5.552.000.00	5.526.140.00	25.860.00	99.53
210401	Бичиг хэрэг	233.500.00	232.100.00	1.400.00	99.4
210402	Тээвэр, шатахуун	2.826.800.00	2.815.000.00	11.800.00	99.58
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	1.000.000.00	1.000.000.00		100
210404	Ном, хэвлэл	485.000.00	481.500.00	3.500.00	99.28
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	1.006.700.00	997.540.00	9.160.00	99.09
2105	Нормативт зардал	316.400.00	316.400.00		100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	316.400.00	316.400.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1.455.000.00	1.426.924.00	28.076.00	98.07
210604	Урсгал засвар	1.455.000.00	1.426.924.00	28.076.00	98.07
2107	Томилолт, зочны зардал	300.000.00	292.000.00	8.000.00	97.33
210702	Дотоод албан томилолт	300.000.00	292.000.00	8.000.00	97.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	1.673.200.00	1.641.254.00	31.946.00	98.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг	1.649.000.00	1.641.254.00	7.746.00	99.53
210807	Газрын төлбөр	24.200.00		24.200.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	291.000.00	291.000.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	291.000.00	291.000.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145.500.00	1.949.773.28	-1.804.273.28	1.340.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	145.500.00	142.000.00	3.500.00	97.59
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	145.500.00	142.000.00	3.500.00	97.59
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт,		1.807.773.28	-1.807.773.28	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1.807.773.28	-1.807.773.28	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	117.425.000.00	116.749.900.00	675.100.00	99.43
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116.575.000.00	116.574.900.00	100	100
132001	Орон нутгийн төсвөөс	116.575.000.00	116.574.900.00	100	100
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС				
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	850.000.00	175.000.00	675.000.00	20.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	850.000.00		850.000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос		175.000.00	-175.000.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрд сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн

тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд 2 албан шаардлага, 4 зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор С.Шийлэгмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүрд сумын соёлын төв нь иргэдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх, түүх, соёлоо сурталчлах иргэдэд үзүүлэх соёл, иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй, тэдний санаа бодолд нийцүүлэн хэрэгцээг хангахуйц соёл мэдээллийн цогц орчинг бий болгох зорилго, чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын даргын тушаалаар батлагдсан журмын дагуу нэг ажилтан дотоод хяналт, шалгалтыг хавсран хариуцаж ажилладаг ба жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан ажилладаг байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрд сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 121.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувь буюу 0.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 57.1 сая төгрөгөөр өссөн байгаа нь барилга байгууламжид их засвар хийгдэж хөрөнгийг капиталжуулсан байна.
- Бараа материалын үлдэгдэл 0.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Өглөгийн дансанд оны эхэнд 2.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцсээр өглөгийг барагдуулсан байна.
- Урьд онд авлагын дансанд үлдэгдэлтэй байсан 1,048.8 мянган төгрөгийн ажиллагчидтай холбогдсон авлагаас 48.8 мянган төгрөг барагдаж, үлдэгдэл болох 1,000.0 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 116.1 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 116.6 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 116.6 сая төгрөгөөр батлагдаж, санхүүжилт бүрэн хийгдсэн ба үүнээс 1.8 сая төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Оны нийт төсвийн гүйцэтгэл 114.8 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бүрд сумын соёлын төвд тайлант онд нэмэлт санхүүжилтийн гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Тус байгууллага нь Үндсэн хөрөнгө болон бараа материалыг хагас, бүтэн жилээр тооллого хийгээгүй, Тээвэр шатахууны зарцуулалтад тайлан гаргаагүй, жолоочийн замын хуудасгүй, зарцуулалтад тавих хяналт маш сул зэрэг зөрчлүүдийг дахин гаргахгүй байхад анхаарч албан шаардлага хүргүүлсэн.

Газар эзэмших эрх болон номын фондын хөрөнгийн ашиглах хугацааны бүртгэл, номыг нэр төрлөөр бүртгээгүй алдааг залруулахаар зөвлөмж өгснийг дор дэлгэрэнгүй дурьдах болно. Үүнээс бусад эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэхэд алдаа зөрчил илрээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бүрд сумын соёлын төв нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд Төрийн аудитын газраас итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулахаар онцлох асуудал.

- Хөрөнгийн тооллогыг Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх.
- Бараа материалын дэлгэрэнгүй тайланг гаргаж хэвших.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,431.6 сая төгрөгийн алдаа илэрсэн.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар 2 Албан шаардлага бичигдсэн.

1. Тус байгууллагын жилийн эцсийн тооллогын комиссын тушаал гарсан боловч үндсэн хөрөнгө болон бараа материалын нийт 1,377.8 сая төгрөгийн хөрөнгийн тооллого хийсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Мөн хагас жилийн тооллого хийсэн баримт материал байхгүй байна.

2. Шатахуун зарцуулалтын анхан шатны баримт бүрдүүлээгүй, замын хуудас үйлдэж тооцоо бодоогүйгээс 2.8 сая төгрөгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааны бүртгэлийн асуудал

1.1. Илрүүлэлт:

Газар эзэмших эрх, номын фонд дансны хөрөнгийн ашиглах хугацааг 0 жилээр тооцож санхүүгийн програмд тусгасан.

1.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн бүртгэлд газар эзэмших эрх, номын фонд дансдын хөрөнгийн ашиглах хугацааг залруулан бүртгэх

2. Үндсэн хөрөнгийн ангилал асуудал

2.1. Илрүүлэлт:

Бусад үндсэн хөрөнгийн дансанд газар, номыг хамт бүртгэсэн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Бусад үндсэн хөрөнгийн дансанд газар 2.3 сая төгрөг, ном 20.4 сая төгрөгийн бүртгэлтэй байгааг залруулан бүртгэх.

3. Үндсэн хөрөнгийн бүртгэл асуудал

3.1. Илрүүлэлт:

Номын фондын 20.4 сая төгрөгийн номыг бөөн дүнгээр бүртгэсэн тул тоо ширхэг, нэгж үнэ нь тодорхойгүй байгаагаас тооллогод хамрагдсан эсэх, хөрөнгө бодитоор оршин буй эсэх нь тодорхойгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн номын фонд дансанд бүртгэлтэй хөрөнгийг санхүүгийн бүртгэлд нэр төрлөөр нэг бүрчлэн тусгаж, тооллогыг чанартай гүйцэтгэж хэвших, чанар байдалд нь дүгнэлт хийх.

4. Бараа материал асуудал

4.1. Илрүүлэлт:

Бараа материалын тайлан болон орлого, зарлага, шаардах хуудсыг батлагдсан маягтын дагуу хөтөлж тайланг гаргаагүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу Бараа материалын тайлан болон орлого, зарлага, шаардах хуудсыг хөтөлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бүрд сумын соёлын төв	6	1,431.6	0	0	0	0	2	1,380.6	4	51.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

С.ШИЙЛЭГМАА

